



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 5/48

Хэрлэн сум

Бүтэц, орон тоо, дүрмийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Засгийн газрын 2014 оны “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 327 дугаар тогтоол, 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын гарын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол, 2022 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн хяналт, аудитын албаны чиг үүрэг, нэршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц, орон тоог баталсугай.


2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтцийг нэгдүгээр хавсралтаар, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тооны жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, байгууллагын дүрмийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт нийцүүлэн, алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан батлуулах, ажиллахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Пүрэвжав)-д үүрэг болгосугай.

4. Захирамжын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 13-ны А/267 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 12-ны Б.К.8 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ БҮТЭЦ






Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 12-ны
5/48 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ,
ЗЭРЭГЛЭЛ, ОРОН ТОО**

№	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Алба хаагчийн тоо
1	Дарга /Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч/	ТЗ-4	1
2	Ахлах дотоод аудитор /Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч/	ТЗ-6	1
3	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	ТЗ-6	1
4	Санхүүгийн хяналт шалгалтын байцаагч	ТЗ-7	3
5	Дотоод аудитор /Санхүүгийн хяналт шалгалтын байцаагч/	ТЗ-7	3
6	Архив, бичиг хэргийн ажилтан /нярав, жолооч/	ТҮ-5	1
7	Нийт		10



Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 12-ны дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба /цаашид алба гэх/ нь төсөв, санхүүгийн чиглэлийн хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, ер төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт дотоод аудит хийх, ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага, аж ахуйн нэгжийн засаглал, эрсдлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоонд дотоод аудит хийж үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага бөгөөд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсөв санхүү, дотоод аудитын холбогдолтой хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам гэрээ болон дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын хүрээ, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хөтөлбөр, арга зүй, Засаг даргын шийдвэр, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон мөрдөж ажиллана.

1.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж нь түүний эрхлэх асуудлын хүрээний төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд хяналт тавина.

1.4. Алба нь тогтоосон журмын дагуу хийгдсэн билэгдэл, тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба Төрийн санд данстай байна.

1.5. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрмийг аймгийн Засаг дарга батлах бөгөөд батлагдсан дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авна.

Хоёр. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны удирдлага, зохион байгуулалт

2.1 Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Засаг даргын удирдлагад ажиллаж, ажлаа тайлагнана, дотоод аудитын хороо нь албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, албаны үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

2.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 10 орон тоотой ажиллана. Алба нь дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 3, ахлах дотоод аудитор /санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч/ 1, дотоод аудитор /санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч/ 3, архив, бичиг хэргийн ажилтан /нярав, жолооч/ 1, гэсэн бүтэц орон тоотойгоор үйл ажиллагаа явуулна.

2.3. Албаны орон тоо, цалингийн санг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн тухай хуулийн дагуу жил бүр тогтоож, төсөвт зардлыг тухайн жилийн аймгийн төсөвт тусгана.

2.4.Албаны даргыг албан тушаалын тодорхойлолтод тусгасан шаардлага, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Санхүүгийн хяналт шалгалтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцөн, аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

2.5.Албаны дарга нь аймгийн Засаг даргаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянуулж, дүгнүүлж, Дотоод аудитын хороонд ажлаа тайлагнаж ажиллана.

2.6.Албаны дарга нь Дотоод аудитын хороотой шууд мэдээлэл солилцож, аливаа хориг саадгүй харилцана.

2.7.Албаны дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргах ба байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээг сахиулж, ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт бүрэн бүтэн байдал, албаны хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

2.8.Дарга ажилтнуудтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, хариуцлагын гэрээ, хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын үр дүнг бодитойгоор үнэлж, дүгнэнэ.

2.9.Дарга нь батлагдсан бүтэц, холбогдох хууль, журмын дагуу батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажилтнуудыг тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан тавигдах шаардлага, нөхцөл болзлыг хангасан иргэнийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулж томилж, чөлөөлнө.

2.10.Албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг аймгийн Засаг дарга холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж төрийн албаны Зөвлөлөөр батлуулан мөрдүүлж ажиллана. Албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, ахлах дотоод аудитор /улсын ахлах байцаагч/, дотоод аудитор нарын албан тушаалын тодорхойлолтыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж төрийн албаны зөвлөлөөр батлуулж мөрдүүлж ажиллана. Архив, бичиг хэргийн ажилтаны /нярав, жолооч/ албан тушаалын тодорхойлолтыг албаны дарга холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, баталж, мөрдүүлж, ажиллана.

2.11.Албаны албан хаагчид нь энэхүү дүрэм болон албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ба байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөнө.

2.12. Алба нь санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааны явц байдал, үр дүнгийн талаар аймгийн Засаг даргад танилцуулна.

2.13.Алба нь Архив, бичиг хэргийн ажилтан /нярав, жолооч/-тай хөдөлмөрийн гэрээ байгуулна.

2.14. Алба нь санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

2.15.Алба нь гүйцэтгэсэн хяналт шалгалтын дүн, дотоод аудитын ажлын тайланг Дотоод аудитын хороонд тайлагнаж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллана.

2.16.Алба нь орон нутгийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй ажлаа уялдуулна.

2.17.Төсвийн ерөнхийлөн захирагч нь дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт болон уг үйл ажиллагааг баримтжуулалтад зайлшгүй хэрэглэх техник, тоног төхөөрөмж, дотоод аудитор чиг үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж ажиллана.

Гурав. Үйл ажиллагааны зорилго

3.1.Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого,

зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах хангах чиглэлээр шалгагдсан байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дөрөв. Үйл ажиллагааны зарчим

4.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын дүнг бодитой үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчим баримтлана.

4.2. Дотоод аудитын нэгж нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад холбогдох дотоод аудитын нэгжтэй нь зөвшилцсөний үндсэн дээр зохих журмын дагуу санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийнэ.

Тав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

5.1. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь дараахь чиглэлтэй байна.

5.1.1. Санхүүгийн хяналт шалгалтын талаар:

5.1.1.1. Төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, заавар, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт, дотоод аудит хийх.

5.1.1.2. Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт байгууллагын хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, төсвийг зүй зохистой, үр ашигтай зарцуулсан байдалд хяналт шалгалт, дотоод аудит хийх.

5.1.1.3. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, ашиглалт, бүртгэл, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт;

5.1.1.4. Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт шалгалт хийх.

5.1.1.5. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт шалгалт хийх.

5.1.1.6. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайланд тусгагдсан байдал ;

5.1.1.7. Гэрээний үндсэн дээр улс, орон нутгийн өмч, хөрөнгөөр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх.

5.1.1.8. Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас төрд учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх чиглэлээр хяналт шалгалт хийх.

5.1.1.9. Орон нутгийн татварын орлого бүрдүүлэлтэд хяналт шалгалт хийх.

5.1.2. Дотоод аудитын талаар:

5.1.2.1. Байгууллагын дотоод хяналтын болон засаглалын байдалд аудит хийх;

5.1.2.2. Эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдалд аудит хийх;

5.1.2.3. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, орлогын бүрдүүлэлтэд дотоод аудит хийх .

5.1.2.4. Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв найдвартай байдалд аудит хийх;
5.1.2.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тусгайлан явуулах аудит;

5.1.2.6. Холбогдох хууль тогтоомж, стандартын хүрээнд тодорхойлсон бусад аудит;

5.1.2.7. Батлагдсан орон тоо, цалингийн санд дотоод аудит хийх.

5.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцсэн, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан стандарт, арга зүйн хүрээнд явагдана.

5.3. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, /ахлах/ дотоод аудитор нь шалгалтаар тогтоогдсон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон танилцуулга, тайлан, дүгнэлт, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоох албан шаардлага, төрд учирсан хохирлыг төлүүлэх акт бичнэ.

Зургаа. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудиторын эрх үүрэг

6.1. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, /ахлах/ дотоод аудиторууд нь дараахь эрхтэй байна.

6.1.1. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдагч байгууллагын дотоод нэгж, хэсгүүдийн үйл ажиллагаатай танилцах;

6.1.2. Холбогдох албан хаагчтай уулзалт, ярилцлага хийх;

6.1.3. Санхүүгийн хяналт шалгалт аудитад хамаарах, бичмэл болон цахим баримт, мэдээлэл, материалыг гаргуулан авах, хяналт шалгалт хийх, объектод саадгүй нэвтрэх;

6.1.4. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаанд шаардлагатай байр, тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглах;

6.1.5. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар санхүүгийн тайлан, баримтыг баталгаажуулахтай шууд холбоотой баримт бичигтэй танилцах хүсэлтэй прокурорын байгууллагаас зөвшөөрөл авч холбогдох банк санхүүгийн байгууллагад тавих;

6.1.6. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах.

6.1.7. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх

6.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор нь дараахь үүрэгтэй байна.

6.2.1. Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, төрийн захиргааны албан хаагчийн болон Олон улсын аудиторуудын институтээс гаргасан дотоод аудитын ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах;

6.2.2. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын явцад олж авсан мэдээллийн нууцыг хадгалах;

6.2.3. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын явцад танилцсан, олж авсан, бүх баримт бичиг, мэдээллийг зөвхөн хяналт шалгалтын болон дотоод аудитын үйл ажиллагаанд ашиглах;

6.2.4. Мэргэжлийн мэдлэг чадвараа тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх;

6.2.5. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, дотоод аудитор нь аливаа асуудалд шударга бодит байдалд нийцүүлэн хандах бөгөөд хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;

6.2.6. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор нь Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон байгууллагын дотоод журмыг ёсчлон биелүүлэх үүрэгтэй.

6.2.7. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын тэмдэглэл, танилцуулга, тайлан, дүгнэлт, зөвлөмж, албан шаардлага, актыг хууль тогтоомжид нийцүүлэн, баримт нотолгоонд үндэслэн гаргах ба шалгалтын материалд тусгагдсан тоо баримт, мэдээллийн үнэн зөвийг хариуцах.

6.2.8. Хяналт шалгалтын акт, материалыг шалгуулсан этгээдэд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулах.

6.2.9. Шалгалт. Дотоод аудитын дүнгээс гарсан аливаа шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, түүнийг хангуулах арга хэмжээ авах ба биелэлтийг нотолсон баримтыг цуглуулсан байх.

6.2.10. Шалгалтын дүнгээр гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, хангуулах арга хэмжээ авах;

6.2.11. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илэрсэн зөрчил, дутагдал нь авлига, ашиг сонирхол, гэмт хэргийн шинжтэй байвал холбогдох байгууллагад уламжлах.

Долоо. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг төлөвлөх, хэрэгжүүлэх үе шат

7.1. Алба нь байгууллагын стратеги төлөвлөгөө, дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөг тус бүр жилээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 жилээр боловсруулах, дотоодын аудитын хороогоор хэлэлцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.

7.2. Албаны жилийн төлөвлөгөөний дагуу санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг явуулахдаа төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах, санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаас гарсан шийдвэр, зөвлөмжийн мөрөөр ажиллах гэсэн үе шатыг баримтлан гүйцэтгэнэ.

7.3. Санхүүгийн хяналт шалгалт хийх удирдамжийг албаны дарга, дотоод аудитын удирдамжийг аймгийн Засаг дарга тухай бүр батална.

7.4. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, /ахлах/ дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудитын үйл ажиллагаа явуулж, тайланг бэлтгэн албаны даргад танилцуулж, Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн шийдвэрийг хяналт шалгалт, дотоод аудит хийлгэсэн байгууллага нэгжид хүргүүлнэ.

7.5. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, /ахлах/ дотоод аудитор нь хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага зөвлөмж, түүний мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтэнд улирал тутам хяналт тавьж ажиллана.

7.6. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга дараах асуудлаар Дотоод аудитын хороо, аймгийн Засаг даргад танилцуулж, тайлагнана.

7.6.1. Санхүүгийн хяналт шалгалт болон гүйцэтгэсэн дотоод аудитын дүн.

7.6.2. Санхүүгийн хяналт шалгалт, дотоодын аудитын жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц.

7.6.3. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит болон хөндлөнгийн аудитын акт албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн явц.

7.6.4. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдсэн байгууллага, нэгжийн үйл ажиллагаанд анхаарвал зохих асуудал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох санал.

Найм. Санхүүгийн хяналт дотоод аудитын ажлын баримт

8.1. Санхүүгийн хяналт дотоод аудитын төлөвлөлт, гүйцэтгэл тайлагнал, хяналт шалгалтаар тогтоогдсон акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний үе шат бүрийн явцад хийсэн бүх үйл ажиллагаанд ажлын баримт бэлтгэн зохих стандартын дагуу архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгнө.

8.2. Энэхүү дүрмийн 8.1-д заасан ажлын баримтыг маргаан гарсан тохиолдолд санхүүгийн хяналт, дотоод аудитын үр дүнг магадлах, чанарын хяналтын хараат бус үнэлгээ хийхэд ашиглана.

Ес. Хараат бус байдал

9.1. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа нь бие даасан, хараат бус байдлаар явагдана.

9.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, /ахлах/ дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт зохимжгүй нөлөөллийн талаар албаны дарга, аймгийн Засаг дарга, Дотоод аудитын хороонд мэдээлнэ.

9.3. Аймгийн Засаг дарга нь санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч болон /ахлах/ дотоод аудитор ажил үүргээ хараат бусаар, аливаа нөлөөлөлд автахгүйгээр гүйцэтгэхэд нь бүх талаар дэмжлэг үзүүлж, ажиллах нөхцөл боломжоор хангана.

Арав. Хөндлөнгийн аудитай харилцах

10.1. Алба нь Төрийн аудитын байгууллагатай дараахь хүрээнд хамтран ажиллаж болно.

10.1.1. Жилийн ажлын төлөвлөгөө, тайлангаа харилцан мэдээлэх;

10.1.2. Хамтарсан сургалт зохион байгуулах, арга зүй, туршлага судлах, солилцох

10.1.3. Харилцан мэдээлэл солилцох.

Арван нэг. Байгууллагын удирдлага албан хаагчдын үүрэг

11.1. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг явуулах үед санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, /ахлах/ дотоод аудиторын шаардсан мэдээ, материал, лавлагаа, тайлбарыг хяналт шалгалт, дотоод аудит хийлгэж байгаа байгууллага, хуулийн этгээдийн удирдлага, албан хаагчид хугацаанд нь гаргаж өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд ярилцлага, санал асуулга хийхэд оролцох үүрэгтэй.

11.2. Санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч, /ахлах/ дотоод аудиторын гаргасан акт, албан шаардлага, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг байгууллагын удирдлага албан хаагчид хэрэгжүүлэх үүрэгтэй.

Арван хоёр. Бусад

12.1. Энэ дүрэмд шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд уг өөрчлөлтийг тухай бүр аймгийн Засаг даргаар батлуулж, эрх бүхий байгууллагад мэдэгдэх ба тэдгээр нь дүрмийн бүрэлдхүүн хэсэг болж мөрдөгдөнө.

12.2. Энэ дүрэмд орсон өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.